БАТЛАВ.
ХҮН АМ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
СУРГАЛТ, СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭНГИЙН
ЗАХИРАЛ М.БАТГЭРЭЛ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЗАЙНААС, ЦАХИМ БОЛОН БОГИНО ЦАГААР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ БОЛОМЖ СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТЫН АЖЛЫН ДААЛГАВАР

ЗОРИЛГО

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдал, хөдөлмөр эрхлэх сонирхол болон цахимаар болон богино цагаар хөдөлмөр эрхлэх боломжийг судлах, дэд бүтцийн хүртээмж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлж буй байдлыг тодорхойлох судалгааны мэдээлэл цуглуулалтын ажлыг сонгогдсон аймаг, дүүргийн хэмжээнд зохион байгуулах, түүвэрт сонгогдсон иргэдээс бүрэн мэдээлэл цуглуулах ажлыг захиалагчийн удирдлага, хяналт дор гүйцэтгэх.

ЗОРИЛТ

- Судалгаа зохион байгуулах байгууллага болон гэрээт судлаач нартай хамтран ажиллах гэрээг байгуулах
- Судалгаа зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж, мэдээлэл цуглуулах судлаачдад сургалтыг зохион байгуулж, судалгаа асуулгыг бөглөх зааврыг танилцуулах
- Туршилтын судалгааг зохион байгуулах. Үүнд: Улаанбаатар хотын хэмжээнд судалгааны түүвэрт сонгогдсон дүүргээс өөр дүүрэгт зохион байгуулж, туршилтын судалгааны тайланг захиалагч талд хүргүүлэх;
- Түүвэрт сонгогдсон иргэдээс шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээллийг бүрэн цуглуулах
- Мэдээллийг CSPro программ дээр цуглуулан, уг программ болон SPSS программд захиалагчийн шаардлагын дагуу хөрвүүлэх, судалгааны анхан шатны мэдээллийн чанарыг өндөр түвшинд хангах;
- Судалгааны мэдээлэл цуглуулалтаар үүссэн мэдээллийн сан болон судалгаа авах явцын бүх аудио бичлэг, бусад холбогдох баримт бичгийг архивын стандартаар бэлтгэн захиалагчид хүлээлгэн өгөх;
- Гүйцэтгэсэн ажлын гэрээ дүгнэсэн акт, дүгнэлт, тайланг өгөгдсөн зааврын дагуу бэлтгэж захиалагчид хүлээлгэх өгөх;
- Гэрээнд заасан ажил гүйцэтгэх хугацааг чанд баримтлан ажиллах.

АЖЛЫН АГУУЛГА, ХЭМЖЭЭ

Хамрах хүрээ:

Судалгааны эх олонлог нь Үндэсний статистикийн хорооны 2024 оны жилийн эцсийн байдлаарх зарласан хөгжлийн бэрхшээлтэй иргэн байх ба зорилтот эх олонлог нь 19-65 насны хөдөлмөр эрхлэх боломжтой хөгжлийн бэрхшээлтэй иргэд байх бөгөөд судалгааны мэдээлэл цуглуулалтын үйл ажиллагааг сонгогдсон 4 аймаг буюу Завхан, Өвөрхангай, Сэлэнгэ, Дорнод аймагт, Улаанбаатар хотын 5 дүүргийн хэмжээнд зохион байгуулна.

Түүврийн дизайн, түүврийн хэмжээ:

Түүврийн хэмжээг хөдөлмөр эрхлэх насны 19-65 насны боломжит эх олонлогоос хүйс, насны бүлэг, байршил, хөгжлийн бэрхшээлийн төрөл, хөдөлмөр эрхлэлтийн байдлыг төлөөлөх чадвартай, хэмжиж болохуйцаар магадлалт 95 хувийн итгэлцлийн түвшин, 5% хувийн алдааны магадлал гарахаар тооцож магадлалт түүвэрлэлтийн загвараар түүврийн дизайныг 383 хөгжлийн бэрхшээлтэй иргэн , ААНБ-ын тоо 50 байхаар зохион байгуулна.

Мөн уг судалгааны хүрээнд дэд бүтцийн хүртээмжийн байдлыг зам, гудамж талбай, нийтийн тээвэр, ААНБ буюу барилга байгууламжийн хүрээнд хүртээмжийг үнэлэх ажлыг сонгогдсон аймаг, дүүргийн хэмжээнд зохион байгуулна.

Мэдээлэл цуглуулах ажлын хүрээнд:

Бэлтгэл үе шат:

Захиалагчийн ажлын даалгаварт нийцсэн үйлчилгээний ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг хүлээн зөвшөөрч, ажил гүйцэтгэх гэрээг баталгаажуулах, мэдээлэл цуглуулах судлаач нарт сургалт зохион байгуулах, туршилтын судалгааг явуулах, асуулга болон судалгааны программ хангамж, техникийн хангамжийн бүрэн ажиллах нөхцөлийг бүрдүүлж, үйл ажиллагааны тайлан ирүүлэх;

Гүйцэтгэлийн үе шат:

- Мэдээлэл цуглуулалтыг Улаанбаатар хотын мэдээлэл цуглуулалтыг эхлүүлж, дараагийн шатанд хөдөө орон нутагт мэдээлэл цуглуулалтыг үргэлжлүүлэх, анхдагч мэдээллийн сан бүрдүүлэх;
- Ажлын явцын гүйцэтгэлийн тайланг захиалагч талд 7 өдөр бүр ирүүлэх;
- Мэдээлэл цуглуулах ажлыг 100 хувьтай гүйцэтгэх.

Хяналтын үе шат:

Мэдээлэл цуглуулах явцад үүссэн мэдээллийн санд өдөт тутмын хяналт хийж, үр дүнг цахим хэлбэрээр захиалагч талд хүсэлтийн дагуу ирүүлэх, нөөц түүвэрт шилжсэн тохиолдол бүрийн дэлгэрэнгүй бүртгэл хийх.

Биелэлтийн үе шат:

Мэдээллийн санг цэвэрлэн дата мэдээллийг тайланд ашиглахад бэлэн болгох, дээр заагдсан статистикийн программд хөрвүүлэх, захиалагчийн хяналтад өгөх, асуулгыг архивлах, журмын дагуу хүлээлгэн өгөх.

Мэдээлэл цуглуулах хэрэгсэл:

Судалгааны мэдээлэл цуглуулах хэрэгсэн нь захиалагчаас боловсруулсан асуулга байна. Судалгааны мэдээлэл цуглуулалтыг 100% урьдчилан бэлтгэсэн таблет дээр мэдээлэл цуглуулалтын хийж гүйцэтгэнэ. Судалгааны явц болон ярилцлага бүрийн аудио бичлэг хийх, үүссэн мэдээллийн санд тухай бүр хяналт хийх зэрэг мөн цаашлаад судалгааны бүхий л үе шатад сүүлийн үеийн технологид суурилсан арга зүй, техник, тоног төхөөрөмж ашиглахыг дэмжинэ.

- ✓ Судалгааны мэдээлэл цуглуулах хэрэгсэл нь захиалагчаас бэлтгэж, баталсан судалгааны маягт байна.
- ✓ Асуулгад зарцуулах хугацааг урьдчилсан байдлаар 20 минутаас хэтрүүлэхгүй байхаар тооцоолсон.
- ✓ Туршилтын судалгааг явуулж, асуулгыг захиалагч, гүйцэтгэгчийн хамтын оролцоотойгоор засварлан мэдээлэл цуглуулалтад бэлэн болгоно.

- ✓ Захиалагчтай харилцан тохиролцсоны үндсэн дээр мэдээлэл цуглуулалтыг таблет болон дуу хураагуур ашиглан хийж гүйцэтгэнэ.
- ✓ Судалгааны мэдээллийн үнэн зөв байдал, чанарыг баталгаажуулах үүднээс дуу хураагч ашиглах боломжтой сүүлийн үеийн төхөөрөмж /таблет/ байна.

Мэдээлэл цуглуулах ажлын ерөнхий хуваарь:

1. Мэдээлэл цуглуулалтын бэлтгэл ажил - 2025.08.11-ээс хуанлийн 7 хоног
2. Мэдээлэл цуглуулалт үргэлжлэх хугацаа - 2025.08.15-2025.08.30 өдөр хүртэл
3. Нэгдсэн мэдээллийн сан, бичиг баримт хүлээлгэн өгөх - 2025.09.15 өдөр

Нийт хуанлийн хоног - 36

Нийт ажлын хоног – 25

ГҮЙЦЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Гүйцэтгэгч байгууллагад дараах шаардлага тавигдана. Үүнд:

1. Оролцогч байгууллага санхүүгийн, хүний нөөцийн чадамж, болоод бусад шалгууруудыг хангах /мэдээлэл цуглуулах баг гишүүн байна/;
2. *Байгууллага нь с*үүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо
3. Гэрээний үүргээ зөрчөөгүй байх;
4. Уг тендерт оролцогч нь өөр хуулийн этгээдтэй түншлэл үүсгэн оролцож, болохгүйг анхаарах;
5. Судалгааны багийн гишүүд нийгмийн даатгалын тодорхойлолт сүүлийн нэг жилээр/ байх;
6. Олон улсын байгууллагуудын судалгааны ажлуудад оролцож, байсан бол давуу тал болно.
7. Зөвлөх багийн гишүүдийн 50 хүртэлх хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байх.
8. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагатай байх.

Удирдлага/ажилтан	Тавигдах шаардлага
Удирдлага зохион байгуулалтаар хангах багийн ахлагч / 1 хүн /	Боловсрол: ✓ Их дээд сургууль төгссөн бакалавраас дээш боловсролтой байх; ✓ Социологич, хүн ам зүй болон дүйцэхүйц мэргэжлийн чиглэлээр төгссөн байх; Туршлага: ✓ Судалгааны мэдээлэл цуглуулалтын баг нь хуулийн этгээд байх бөгөөд холбогдох чиглэлээр доод тал нь 5 жил хүртэлх ажлын туршлагатай байх;
Дата аналист /багийн гишүүн 2 хүн/	Боловсрол: ✓ Эдийн засаг, статистик, социологи, хүн ам зүйч болон дүйцэхүйц мэргэжлийн чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх; Туршлага: ✓ 3-аас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан туршлагатай; ✓ Төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж байсан туршлагатай; ✓ SPSS болон бусад мэргэжлийн программ дээр ажиллах чадвартай; ✓ Эдийн засаг, статистикаар мэргэшсэн байх; ✓ Тухайн байгууллагын үндсэн ажилтан байх; ✓ Хөгжлийн бэрхшээлийн чиглэлээр ажилласан туршлагатай байх;
Мэдээлэл цуглуулагч /багийн гишүүн 12 хүн/	Боловсрол: ✓ Их дээд сургууль төгссөн бакалавраас дээш боловсролтой бол давуу тал болно; Туршлага: ✓ Хөгжлийн бэрхшээлийн төрөл хэлбэрийн онцлогт тохируулан харилцах ур чадвартай байх; ✓ Хөгжлийн бэрхшээлийн чиглэлээр хийгдсэн судалгаа хийсэн, эсхүл мэдээлэл цуглуулагчаар ажилласан туршлагатай байх;

Жолооч /багийн гишүүн – 5 хүн/	✓ Жолооний хүчинтэй үнэмлэхтэй байх; ✓ Сүүлийн 5 жил тасралтгүй жолоо барьсан байх;

Төлбөр төлөх хуваарь:

(a) Гэрээний үнийн дүнгийн 40 хувьтай тэнцэх дүнг мэдээлэл цуглуулах бэлтгэл ажлыг гүйцэтгэсэн тухай гүйцэтгэгч байгууллагын ирүүлсэн эхлэлтийн тайланг захиалагч хүлээн авсны дараа төлнө.

(b) Гэрээний үнийн дүнгийн 40 хувьтай тэнцэх дүнг мэдээлэл цуглуулах бэлтгэл ажлын 75 ба түүнээс дээш гүйцэтгэсэн байх ба гүйцэтгэгч байгууллага захилдагчид дунд хугацааны тайланг ирүүлсний дараа төлнө.

(c) Гэрээний үнийн дүнгийн 20 хувьтай тэнцэх дүнг мэдээлэл цуглуулах бэлтгэл ажлын 100 хувь гүйцэтгэсэн байх ба гүйцэтгэгч байгууллага захилдагчид эцсийн тайланг хүлээн зөвшөөрч, ажлаа бүрэн дүүрэн дуусгасны дараа төлнө.

- ✓ Захиалагч болон гүйцэтгэгчийн хооронд байгуулах гэрээнд хугацааг тодорхой тусгах бөгөөд гэрээнд заасан хугацаанд багтаан гэрээний ажлыг гүйцэтгэнэ.
- ✓ Хоёр тал гэрээ байгуулснаар ажил эхэлж, захиалагч тал судалгааны ажлыг хүлээн авч, тайлантай танилцаж, гэрээ дүгнэсэн акт, хурлын тэмдэглэлд гарын үсэг зурснаар дуусгавар болно.

Мэдээлэл цуглуулалтын хэрэгсэлд:

Мэдээлэл цуглуулалтын хэрэгсэл	Тавигдах шаардлага
Тоног төхөөрөмж	• Дата мэдээллийг засварлаж, илгээхэд шаардлагатай зөөврийн компьютер 7 ширхэг байх; • Судалгааны мэдээллийн үнэн зөв байдал, чанарыг баталгаажуулах үүднээс дуу хураагч ашиглах боломжтой сүүлийн үеийн төхөөрөмж /таблет/ нийт 13 ширхэг байх;
Тээврийн хэрэгсэл	• Техникийн бүрэн бүтэн байдлыг хангасан тээврийн хэрэгсэл байх; • Тав тухтай, аюулгүй зорчих боломжийг хангасан байх; • Авто тээврийн тухай хууль тогтоомж, дүрэм, журам болон тэдгээрийг хэрэгжүүлэхээр эрх бүхий

	байгууллагаас гаргасан шийдвэрийн дагуу зорчигч тээврийн үйлчилгээг зохион байгуулах;

Гүйцэтгэгч байгууллагын аюулгүй байдал:

Гүйцэтгэгч байгууллага мэдээлэл цуглуулалтыг талбарт гүйцэтгэж буй судлаачдын аюулгүй байдлыг бүрэн хариуцна. Судлаач нарт зориулсан сургалтад энэ талаар дэлгэрэнгүй зөвлөгөө мэдээлэл өгөх, аюулгүй байдлыг дараах байдлаар хангаж ажиллана.

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАГЧДЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЗААВАРЧИЛГАА

Нэг. Мэдээлэл цуглуулагч нарын аюулгүй ажиллагааны бэлтгэл хангах

1.1 Мэдээлэл цуглуулалтын аюулгүй ажиллагааны төлөвлөгөө, нарийвчилсан зааварчилгааг ирүүлэх талаар ажлын даалгаварт заавал тусгах;

1.2 Мэдээлэл цуглуулагчдад зориулсан сургалтын хөтөлбөрт аюулгүй ажиллагааны хичээлийг нэг цагаас багагүй хугацаанд оруулах, аюулгүй ажиллагааны журмын мэдлэгийг мэдээлэл цуглуулагч нараас шалган асуух;

1.3 Мэдээлэл цуглуулагч нарт хөгжлийн бэрхшээлийн хэлбэр тус бүрийн онцлог хэрэгцээ болон харилцах арга зүйн талаар сургалт мэдээллийг хүргэсэн байна.

1.4 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сэтгэлзүйн онцлогийг харгалзаж, туслах судлаачдыг дан хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс бүрдүүлэхэд анхаарах;

Хоёр. Мэдээлэл авахад баримтлах зарчим

2.1 Судалгааны мэдээлэл авахаар өрх /айл/-д орохдоо эхний нэг минут хүртэлх хугацаанд орчны аюулгүй байдалд дүгнэлт гаргахад анхаарах ёстой. Үүнд:

2.1.1 Өрөөнд хэдэн хүн байгааг тодорхойлохыг хичээх;
2.1.2 Согтууруулах ундаа хэрэглэсэн хүн байгаа эсэх;
2.1.3 Сэтгэцийн өвчинтэй хүн байгаа эсэхийг тодорхойлох;
2.1.4 Өрөөнд галт зэвсэг (үүнд үзмэр хэлбэрээр хадгалж байгаа зэвсгийг хамааруулна) байгаа эсэхийг ажиглах;
2.1.5 Ил хүйтэн зэвсэг (хутга, зэвсгийн зорилгоор ашиглаж болох зүйлсийг хамруулна) байгаа эсэхийг ажиглах;
2.1.6 Хаалга дотогшоо, эсвэл гадагшаа онгойдог эсэх, мөн хаалга автоматаар түгжигддэг эсэх, дотор талаасаа шууд онгойлгох боломжтой эсэхийг шалгах;

2.2 Мэдээлэл авах үедээ дараах зүйлүүдэд анхаарах хэрэгтэй

2.2.1 Хаалганд хамгийн ойр байхаар суух ёстой
2.2.3 Ар талаараа хүн явах боломжгүй, хана дагуулж тавьсан сандал дээр суух;
2.2.4 Зөвхөн зөвшөөрөгдсөн тээврийн хэрэгслээр орон нутагт зорчих;
2.2.5 Мэдээлэл цуглуулалтыг ажлын цагаар хийж гүйцэтгэх;

Гурав. Аюулгүй байдлыг дээшлүүлэх багаж хэрэгсэл

3.1 Мэдээлэл цуглуулагч нарын аюулгүй байдлыг хангах зорилгоор дараах багаж хэрэгслээр хангана.

3.1.1 Хурц тусдаг гар чийдэн
3.1.2 Чанга дуу гаргагч